



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БНА-2022/151/НА-СТА-ТШЗ**

<p>Баянхонгор 2022 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576      Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a> Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140      Цахим хаяг: <a href="mailto:tseenyama@audit.gov.mn">tseenyama@audit.gov.mn</a> Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866      Цахим хаяг: <a href="mailto:bunchinsurenn@audit.gov.mn">bunchinsurenn@audit.gov.mn</a>  Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p>
-------------------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан .....	9
3.1 Ерөнхий зүйл .....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	13
4. Аудитын илрүүлэлт .....	13
4.1 Аудитын зөвлөмж .....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.16 № 2/12

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D- alban bichig 2022 A4 TOOT

0050?0?06

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Б.МӨНХБАТ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>7,772,750.02</b>	<b>10,570,800.02</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>7,772,750.02</b>	<b>10,570,800.02</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>7,772,750.02</b>	<b>10,570,800.02</b>
35410	Бичиг хэргийн материал	00.00	120,000.00
35420	Аж ахуйн материал	6,516,400.00	10,450,800.00
35440	Түлш, шатах тослох материал	00.02	00.02
35460	Хүнсний материал	1,256,350.00	00.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,414,671,679.29</b>	<b>1,465,228,138.85</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,414,671,679.29</b>	<b>1,465,228,138.85</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,352,443,429.29</b>	<b>1,403,136,388.85</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,411,412,880.00	1,469,674,798.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-112,011,885.78	-114,163,491.60
39203	Авто-тээврийн хэрэгсэл	49,998,000.00	49,998,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-49,998,000.00	-49,998,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	116,411,023.85	13,608,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-108,913,093.53	-3,498,634.53
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	108,311,656.40	104,339,761.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-62,767,151.65	-66,824,044.42
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>62,228,250.00</b>	<b>62,091,750.00</b>
39301	Программ хангамж	1,050,000.00	1,050,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-736,750.00	-873,250.00
39303	Бусад биет бус хөрөнгө	61,915,000.00	61,915,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,422,444,429.31</b>	<b>1,475,798,938.87</b>
<b>6</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,422,444,429.31</b>	<b>1,475,798,938.87</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,422,444,429.31</b>	<b>1,475,798,938.87</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	88,891,360.00	88,891,360.00
51101	Өмч: - төрийн	88,891,360.00	88,891,360.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,175,882,959.75</b>	<b>1,229,237,469.31</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,175,882,959.75	1,175,882,959.75
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	53,354,509.56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	157,670,109.56	157,670,109.56
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,422,444,429.31</b>	<b>1,475,798,938.87</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>152,343,260.00</b>	<b>222,401,918.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>61,261,918.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>00.00</b>	<b>61,261,918.00</b>
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө	00.00	60,211,918.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал	00.00	1,050,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>152,343,260.00</b>	<b>161,140,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>9,607,660.00</b>	<b>9,281,400.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,607,660.00	9,281,400.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>142,735,600.00</b>	<b>151,858,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	142,735,600.00	151,858,600.00

<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>201,332,626.27</b>	<b>168,971,808.44</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>201,332,626.27</b>	<b>168,971,808.44</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>196,912,472.32</b>	<b>168,920,222.78</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>80,035,220.00</b>	<b>90,399,588.92</b>
210101	Үндсэн цалин	79,075,220.00	86,822,979.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	960,000.00	3,576,609.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>10,238,098.55</b>	<b>11,512,343.31</b>
210201	Тэтгэврийн даатгал	7,050,809.35	8,061,191.14
210202	Тэтгэмжийн даатгал	816,830.64	873,915.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	661,405.30	687,187.42
210204	Ажилгүйдлийн даатгал	142,946.66	165,893.09
210205	Эрүүл мэндийн даатгал	1,566,106.60	1,724,155.69
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>14,827,307.00</b>	<b>16,267,122.11</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,209,671.00	1,698,767.11
210302	Түлш, халаалт	10,170,400.00	13,095,819.00
210303	Цэвэр, бохир ус	1,447,236.00	1,472,536.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,402,260.00</b>	<b>4,116,700.00</b>
210401	Бичиг хэрэг	590,200.00	636,200.00
210402	Тээвэр, шатахуун	420,000.00	297,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	269,000.00	290,400.00
210404	Ном, хэвлэл	45,000.00	45,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,117,400.00	2,848,100.00
210408	Бараа материал акалсны зардал	6,960,660.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>23,624,497.50</b>	<b>26,009,955.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	345,350.00	370,000.00
210502	Хоол, хүнс	18,604,147.50	19,969,955.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,675,000.00	5,670,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,400,000.00</b>	<b>1,811,855.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	366,900.00
210604	Урсгал засвар	1,400,000.00	1,444,955.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,612,240.00</b>	<b>7,151,200.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,492,240.00	6,851,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	120,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	180,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>46,772,849.27</b>	<b>11,651,458.44</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,772,849.27	11,651,458.44
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,420,153.95</b>	<b>51,585.66</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>100,000.00</b>	<b>10,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	10,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>4,320,153.95</b>	<b>41,585.66</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,320,153.95	41,385.66
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-48,989,366.27</b>	<b>53,430,109.56</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>75,600.00</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	75,600.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-75,600.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-48,989,366.27</b>	<b>53,354,509.56</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	төгрөгөөр	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>152,343,260.00</b>	<b>161,140,000.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>152,343,260.00</b>	<b>161,140,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>9,607,660.00</b>	<b>9,281,400.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,607,660.00	9,281,400.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>142,735,600.00</b>	<b>151,858,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	142,735,600.00	151,858,600.00

<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>149,485,260.00</b>	<b>159,144,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>149,485,260.00</b>	<b>159,144,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>145,065,106.05</b>	<b>159,092,414.34</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>80,086,983.00</b>	<b>90,399,588.92</b>
210101	Үндсэн цалин	79,126,983.00	86,822,979.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	960,000.00	3,576,609.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>10,238,098.55</b>	<b>11,512,343.31</b>
210201	Тэтгэврийн даатгал	7,032,044.76	8,061,191.14
210202	Тэтгэмжийн даатгал	679,304.43	873,915.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	785,051.81	687,187.42
210204	Ажилгүйдлийн даатгал	155,832.85	165,893.09
210205	Эрүүл мэндийн даатгал	1,585,864.70	1,724,155.69
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>14,827,307.00</b>	<b>16,267,122.11</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,209,671.00	1,698,767.11
210302	Түлш, халаалт	10,170,400.00	13,095,819.00
210303	Цэвэр, бохир ус	1,447,236.00	1,472,536.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,526,600.00</b>	<b>4,470,600.00</b>
210401	Бичиг хэрэг	590,200.00	756,200.00
210402	Тээвэр, шатахуун	420,000.00	297,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	269,000.00	290,400.00
210404	Ном, хэвлэл	45,000.00	45,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,202,400.00	3,082,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>24,721,877.50</b>	<b>24,753,605.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	565,350.00	370,000.00
210502	Хоол, хунс	19,481,527.50	18,713,605.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,675,000.00	5,670,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,562,000.00</b>	<b>2,107,955.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	162,000.00	708,000.00
210604	Урсгал засвар	1,400,000.00	1,399,955.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,102,240.00</b>	<b>9,581,200.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,982,240.00	9,281,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	120,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	180,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,420,153.95</b>	<b>51,585.66</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>100000.00</b>	<b>10000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	10,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,320,153.95	41,385.66
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>2,858,000.00</b>	<b>1,996,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>2,858,000.00</b>	<b>1,996,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,858,000.00</b>	<b>1,996,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,858,000.00</b>	<b>1,996,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,858,000.00	1,996,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-2,858,000.00</b>	<b>-1,996,000.00</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	төгрөгөөр	
				Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	88,891,360.00	157,670,109.56	1,224,872,326.02	1,471,433,795.58
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	88,891,360.00	157,670,109.56	1,224,872,326.02	1,471,433,795.58
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-48,989,366.27	-48,989,366.27
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	88,891,360.00	157,670,109.56	1,175,882,959.75	1,422,444,429.31
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	88,891,360.00	157,670,109.56	1,175,882,959.75	1,422,444,429.31

**Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	88,891,360.00	157,670,109.56	1,175,882,959.75	1,422,444,429.31
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	53,354,509.56	53,354,509.56
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	88,891,360.00	157,670,109.56	1,229,237,469.31	1,475,798,938.87

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны төгрөгөөр			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	151,858,600.00	151,817,214.34	41,385.7	100.0
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	151,858,600.00	151,817,214.34	41,385.7	100.0
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	151,848,600.00	151,807,214.34	41,385.7	100.0
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	90,401,300.00	90,399,588.92	1,711.1	100.0
210101	Үндсэн цалин	86,309,300.00	86,822,979.92	-513,679.9	100.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,092,000.00	3,576,609.00	515,391.0	87.4
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	11,527,200.00	11,512,343.31	14,856.7	99.9
210201	Тэтгэврийн даатгал	7,838,500.00	8,061,191.14	-222,691.1	102.8
210202	Тэтгэмжийн даатгал	922,100.00	873,915.97	48,184.0	94.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	737,700.00	687,187.42	50,512.6	93.2
210204	Ажилгүйдлийн даатгал	184,500.00	165,893.09	18,606.9	89.9
210205	Эрүүл мэндийн даатгал	1,844,400.00	1,724,155.69	120,244.3	93.5
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	16,286,600.00	16,267,122.11	19,477.9	99.9
210301	Гэрэл, цахилгаан	1,701,200.00	1,698,767.11	2,432.9	99.9
210302	Түлш, халаалт	13,095,900.00	13,095,819.00	81.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,489,500.00	1,472,536.00	16,964.0	98.9
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,470,700.00	4,470,600.00	100.0	100.0
210401	Бичиг хэрэг	590,400.00	756,200.00	-165,800.0	128.1
210402	Тээвэр, шатахуун	420,000.00	297,000.00	123,000.0	70.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	322,300.00	290,400.00	31,900.0	90.1
210404	Ном, хэвлэл	48,000.00	45,000.00	3,000.0	93.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,090,000.00	3,082,000.00	8,000.0	99.7
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	24,757,200.00	24,753,605.00	3,595.0	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	370,000.00	370,000.00	0.0	100.0
210502	Хоол, хүнс	18,717,200.00	18,713,605.00	3,595.0	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,670,000.00	5,670,000.00	0.0	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,105,600.00	4,103,955.00	1,645.0	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,705,600.00	2,704,000.00	1,600.0	99.9
210604	Урсгал засвар	1,400,000.00	1,399,955.00	45.0	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	300,000.00	300,000.00	0.0	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	120,000.00	0.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.00	180,000.00	0.0	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	10,000.00	10,000.00	0.0	100.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	10,000.00	10,000.00	0.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,000.00	10,000.00	0.0	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	151,858,600.00	151,817,214.34	0.0	100.0

1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	151,858,600.00	151,817,214.34	0.0	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	151,858,600.00	151,817,214.34	0.0	100.0
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	10.00	10.00	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	03.00	03.00	0.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00	0.0	100.0
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	10.00	10.00	0.0	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	төгрөгөөр	
		Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>9,607,660.00</b>	<b>9,281,400.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>8,849,660.00</b>	<b>9,281,400.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>8,849,240.00</b>	<b>9,281,200.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,849,240.00</b>	<b>9,281,200.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,849,240.00	9,281,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>420.00</b>	<b>200.00</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>420.00</b>	<b>200.00</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	420.00	200.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>758,000.00</b>	<b>-</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	758,000.00	-
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	758,000.00	-
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>9,607,660.00</b>	<b>9,281,400.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>9,607,660.00</b>	<b>9,281,400.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,607,660.00	9,281,400.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бунчинсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022-ны 1 дүгээр сарын 04 өдрийн 06 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах ХХҮГ-ын дарга Д.Амарсанаа, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Г.Түмэннасан нар зурж байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төв нь “Тэжээн тэтгэх хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие, эсхүл тэжээн тэтгэх хүүхэд нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлийн улмаас дэмжлэг үзүүлэх нь тогтоогдсон ахмад настныг асрах үйлчилгээ”-г зохион байгуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 201,332.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,020.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,114.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 2,659.6 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 53,354.5 мянган төгрөгөөр буюу 3.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>7,772.8</b>	<b>10,570.8</b>	<b>2,798.1</b>
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	7,772.8	10,570.8	2,798.1
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,414,671.7</b>	<b>1,465,228.1</b>	<b>50,556.5</b>
Үндсэн хөрөнгө	1,749,098.6	1,700,585.6	(48,513.0)
Хуримтлагдсан элэгдэл	(334,426.9)	(235,357.4)	99,069.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,422,444.4</b>	<b>1,475,798.9</b>	<b>53,354.5</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,422,444.4	1,475,798.9	53,354.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,422,444.4</b>	<b>1,475,798.9</b>	<b>53,354.5</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 10,570.8 мянган төгрөг болж 2,798.1 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,700,585.6 мянган төгрөг болж 48,513.0 мянган төгрөгөөр буурсан нь Баянхонгор аймгийн ИТХ-ын 2021.12.28-ны өдрийн 156 дугаар тогтоолоор 110,720.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан, мөн Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн хүрээнд Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн барилгад 58,261.9 мянган төгрөгийн их засвар хийж капиталжуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,467,465.9 мянган төгрөг болж 53,354.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 53,354.5 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 223,254.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 223,254.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 77,880.7 мянган төгрөгөөр бууруулж 145,373.6 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 151,858.6 мянган төгрөг болгож 6,485.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021.05.12-ны өдрийн 140 дүгээр тогтоолоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа төрийн үйлчилгээний зарим албан хаагчдад хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох журам”-аар хөгжлийн бэрхшээлтэй хүнд сэргээн засах, тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эмч, сувилагч, туслах сувилагч, асрагч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, сэтгэл засалчид тухайн ажил, албан тушаал эрхлэх хугацаанд нь албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг тухайн оны 5 сараас нэмэгдүүлж олгосонтой холбоотой төсөвт тодотгол хийсэн байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 151,858.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 151,858.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 151,858.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 151,817.2 мянган төгрөгийг зарцуулж 41.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 151,817.2 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлаас 1.7 мянга, ажил олгогчоос төлөх НДШ-ээс 14.8 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 19.5 мянган төгрөг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013.10.18-ны өдрийн А/156 дугаар тушаалаар батлагдсан “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настан 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэтгэвэр олгох” журмын дагуу тайлант онд 11 асруулагчаас 9,281.4 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан “Түүвэрт хамрагдсан” ба аудитор Ж.Өсөхбаяр аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилго, 5 зорилтын хүрээнд 26 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 99.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 177,304.8 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 24,027.8 мянган төгрөгөөр буюу 11.9 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой зардал, нормативд зардал, эд хогшил, урсгал засварын зардал тус тус нэмэгдсэн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар

баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 151,848.6 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 145 мэдээллийг хугацаанд нь байршуулж 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	11		
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	1	3	
4	Сар бүр	3	36	35	1	
5	Тухай бүр	8	96	94	2	
	Нийт	27	151	145	6	0

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

Тайлант онд 151,858.6 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж гүйцэтгэлээр 151,817.2 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 41.4 мянган төгрөг буюу төсвийн 0.02 хувийг буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж аваагүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,023.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2,023.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

### 4.1 Аудитын зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2020 онд нийт 151 мэдээллээс төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт боон бусад хяналт шалгалтын дүн, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр зэрэг 6

мэдээллийг хоцроосон нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.1 Эрсдэл: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээллийг хугацаанд мэдээлж байх.

1.2 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

## 2. Зардлын данстай холбоотой асуудал

Тайлант онд хоолны зардлаас 11 асруулагчид 3448 хүн өдөрт нормативаар 17,946.8 мянган төгрөг зарцуулахаар байхад 19,970.0 мянган төгрөг зарцуулж 2023.1 мянган төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан нь Сангийн сайд, Хүн ам хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2013.11.06-ны 247/A/163 дугаар тушаалыг зөрчсөн байна.

2.1. Эрсдэл. Батлагдсан төсвийн хэтрүүлэн зарцуулах

2.2. Өгсөн зөвлөмж: Асруулагчдын хоолны зардлыг хүн өдрийн гүйцэтгэлээр хянаж батлагдсан нормативд өртөгт багтаан зарцуулж байх.

2.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Заруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төв	2	2,023.1							2	2,023.1

оОо